



“СУАТ” ХХК-НЫ 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

БӨА-2017/1/СТА-ОНӨААН



Өлгий-Аудит ХХК

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн
Аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахимхаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахимхаяг: kh_jenisbek@yahoo.com

Өлгий-Аудит ХХК-ийн аудитор:
М.Алтангүл
Утас: 94202122
Цахимхаяг: altik_2006@yahoo.com

ТАБ-ын хаяг: Аймгийн ЗДТГ
Байршил: Өлгий сум 5-р баг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 3 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.12	Шилэн дансны мэдээлэл.....	13
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	13
3	Менежментийн захидал.....	14
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	16
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	16
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	19
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	Error! Bookmark not defined.
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21

1 Аудитын гэрчилгээ



"СУАТ" ХХК-НЫ ЗАХИРАЛ
Ж.АДАЛБЕК ТАНАА

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-29-54
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2017.02.20

№

12-87А-2017/1/СТА.ОНБДАН

танай _____-ны № _____-т

Г

Аудитын гэрчилгээ

Г

Орон нутгийн өмчийн "Суат" ХХК-ны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккрузл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1-д заасан бүрэн эрхийн дагуу Аймагийн аудитын газраас аудит хийв.

"Суат" ХХК-ны удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Орон нутгийн өмчийн "Суат" ХХК-ны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Зөрчилгүй санал дүгнэлт

Орон нутгийн өмчийн "Суат" ХХК-ны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

Аудитын тайлан

1.1 Оршил

“Суат” ХХК-ны захирал Ж.Адалбек танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

1.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.8 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Суат” ХХК-ны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Суат” ХХК-ны 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.02.20-наас 2017.03.15-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.03.15-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Өлгий Аудит” ХХК-ны аудитор М.Алтангүл хариуцаж хэрэгжүүлэв.

"Суат" ХХК-ны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа-нд төрийн аудитын байгууллагад 2017 оны 2 сарын 10-ний өдрийн №37-р албан бичгээр ирүүлсэн байна.

1.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

1.4 Байгууллагын зорилго, үйлажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Суат" ХХК нь *"Хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангаж, бохир усыг татан зайлуулах, халуун усны үйлчилгээ үзүүлэх"* эрхэм зорилгын дор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах
- Цэвэр усны жижиг үйлдвэр
- Бетон эдлэлийн үйлдвэр
- Халуун усны үйлчилгээ

"Суат" ХХК нь дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 1-р зүйлийн 1.1-г "Хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн

барилга байгууламжийг өмчлөх, ашиглах” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна

"Суат" ХХК-ны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

"Суат" ХХК-ны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

1.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

"Суат" ХХК-ны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

"Суат" ХХК-ны санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн Ординат ХХК-ийн "Виница" програм хангамжийг 2009 оноос эхлэн ашиглажээ.

1.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

"Суат" ХХК-ны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 12 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 5 асуудал эрсдэл өндөр, 4 асуудал эрсдэл дунд, 3 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 16 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй Басуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

1.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд сонгосонтой холбоотой юм.

“Сутат” ХХК-ны 2016 санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг 4097,6 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 40,9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1хувиар тооцсон нь эрсдэлийн үнэлгээний түвшинтэй холбоотой юм.

1.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэлтүс бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 7 чиглэлээр 12 эрсдэлтэй асуудалд 18 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100 хувь буюу 12 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	1	27,6	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	1	27,6	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

1.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

1.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

1.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

1.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Үгүй

1.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХБҮЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

"Суат" ХХК-нын 2015 оны эцэст 8,5 сая төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд 2016 онд 242,8 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Иймд дараагийн аудитад хөрөнгийн үр ашигтай зарцуулалтыг хянах шаардлагатай гэж үзэв.

1.11 ТАЙЛАНТ ОНЫ ОРЛОГО, ЗАРДАЛ, САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Мөнгөн хөрөнгийн бүтэц, арилжааны банкин дахь харилцах дансны талаар. "Суат" ХХК нь арилжааны 6 банкинд харилцах данстай байна. Үүнд:

Банкнынэр	дансныдугаар	Эхнийүлдэгдэл	Эцсийнүлдэгдэл
Төрийнбанк	291400002140	685,296.08	781,207.41
Хаанбанк	5180028148	368,736.90	450,761.90
Хасбанк	5000180143	326,002.08	544,835.45
Голомтбанк	5805004633	548,243.16	170,323.44
Капитронбанк	3005007072	178,468.66	164,224.12
Капиталбанк	2034002609	445,490.94	103,564.44
ДҮН		2,552,237.82	2,214,916.76

Оны эхэнд харилцах данснуудад нийтдээ 2,5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 1008,9 сая төгрөгийн орлого, 1009,2 сая төгрөгийн зарлага хийгдэж оны эцэст 2,2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Байгууллагын касс дахь бэлэн мөнгө оны эхэнд 4,0 сая төгрөг байсан ба тайлант онд 251,9 сая төгрөгийн орлого хийгдэж, 247,8 сая төгрөгийн зарлага хийгдэж, оны эцэст 8,1 сая төгрөгийн бэлэн мөнгөний үлдэгдэлтэй гарсан байна.

2. Авлагын бүртгэл, тайлагнал

"Суат" ХХК-ийн оны эхний байгууллагуудаас авах авлага 33,1 сая төгрөг байсан бол оны эцэст 87,7 сая төгрөг болж 2,6 дахин, айл өрхүүдээс авах авлага оны эхэнд 18,6 сая төгрөг байсан бол оны эцэст 30,9 сая төгрөг болж, 1,6 дахин тус тус нэмэгдсэн байна.

Байгууллагаас авах оны эцсийн авлагын бүтэцийг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

	/сая төгрөгөөр/			
Төсөвтбайгууллага	31.41	426.43	425.49	32.35
ҮААГазар	0.05	78.97	62.11	16.92
Блокныүлдрвэр	0.00	6.64	0.00	6.64
Төслийн ажил	1.68	126.07	96.30	31.45
НИЙТ ДҮН	33.14	638.11	583.90	87.35

Дээрх байгууллагын авлагын бүтэцээс харахад төсөвт байгууллагуудын авлага өмнөх оноос нэмэгдээгүй байна. Энэ авлага дотор 2015 онд хэрэглэгч байгууллагуудыг тоолууржуулж хэрэглэсэн усыг тоолуурын заалтаар тооцоо хийхэд гүйцэтгэл нь батлагдсан төсвөөс илүү гарсантай холбоотой үүсч он дамжаад ирж буй Нэгдсэн эмнэлгийн 27,6 сая төгрөгийн авлага ихэнх хувийг эзэлж байна. Нийт 11 байгууллагын тооцоо нийлсэн актыг шалгалаа. Гэвч 5 ба 3-р цэцэрлэг, Боловсрол Соёлын газар гэх мэт төсөвт байгууллагуудаас авах авлага тусгагдсан боловч тооцоо нийлсэн акт үйлдэгдээгүй байна.

Байгууллагуудаас авах авлага нийт дүнгээр 54,2 сая төгрөгөөр нэмэгдэхэд нь Цэнгэл сумын төслийн авлага 31,4 сая төгрөгөөр, ААН Байгууллагуудаас авах авлага 16,8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ. Мөн блокны үйлдвэрт борлуулахад бэлэн байгаа бүтээгдэхүүнийг 6,6 сая төгрөгийг авлагад бүртгэсэн байна.

3. Бараа материалын бүртгэл, тайлагнал

“Суат” ХХК нь 99,4 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан ба тайлант онд 65,5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 80,9 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, оны эцэст 83,9 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарчээ. Жилийн эцсийн бараа материалын үлдэгдлийн 75,3 сая төгрөгийг буюу 89,7 хувийг жижиг тоног төхөөрөмжүүд, 3,5 сая төгрөгийг буюу 4,1 хувийг сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох материал, 3,4 сая төгрөгийг буюу 4 хувийг хангамжийн материалууд, 1,4 сая төгрөгийг буюу 1,7 хувийг Байгууламж ХХК-аас үнэгүй авч ашиглаж буй төслийн бараа материал эзэлж байна.

Тайлант онд үнэ төлбөргүй авсан болон акталсан бараа материал байхгүй байна.

4. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

“Суат” ХХК нь оны эхэнд 5674,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан ба тайлант онд 24,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, байгууллагын барьж буй дуусаагүй барилгад 30,3 сая төгрөгийг зарцуулж, нийт Үндсэн хөрөнгө 56,7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

	с1	с2	Зөрүү
Барилгабайгууламж	4325.6	4325.6	0.0
Тээврийнхэрэгсэл	382.9	382.9	0.0
Машинтоногтөхөөрөмж	738.5	763.1	24.5
Тавилгаэдхогшил	62.8	64.6	1.8
Дуусаагүйбарилгабайгууламж	164.1	194.5	30.3
Програмхангамж	0.6	0.6	0.0
ДҮН	5674.6	5731.3	56.7

“Суат” ХХК нь шинэ байранд нүүж орсон боловч Улсын комиссын акт гэх мэт бичиг баримтууд бүрдээгүй тул 194,5 сая төгрөгийн барилгыг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл:

Тайлант онд нийт 129,7 сая төгрөгийн элэгдэл байгуулж, жилийн эцэст хуримтлагдсан элэгдэл данс 1881,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд 578,0 мян.төгрөгийн үнэтэй программ хангамжийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн ба хорогдол тооцоогүй байна.

Тайлант онд үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө байхгүй байна.

5. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

Тус компани жилийн эцэст нийтдээ 1146,4 сая төгрөгийн өр төлбөртэй гарсаны 991,1 сая төгрөг буюу 86,4 хувь нь урт хугацаат өр төлбөр, 155,4 сая төгрөг буюу 13,6 хувь нь богино хугацаат өр төлбөр байна.

-Богино хугацаат өглөгийн талаар

Оны эхэнд 66,3 сая төгрөгийн богино хугацаат өглөгтэй байснаас оны эцэст 155,4 сая төгрөгийн өглөгтэй гарч оны эхнээс 89,1 сая төгрөгөөр буюу 2,3 дахин нэмэгдсэн байна. Нийт өглөгийн 95,5 сая төгрөг буюу 61,4 хувь нь НӨАТ-татварын өр төлбөр, 15,6 сая төгрөг буюу 10 хувь нь НДШ-ийн өр төлбөр, 17,0 сая төгрөг буюу 10,9 хувь төгрөг нь цахилгааны төлбөр, 12,2 сая төгрөг буюу 7,8 хувь нь тээвэр шатахууны өр, 14,9 сая төгрөг буюу 9,5 хувь нь харуул хамгаалалтын үйлчилгээний өр төлбөр байна. Богино хугацаат өр төлбөрийн дүн өмнөх өмнөх оноос нэмэгдэхэд нь НӨАТ-татварын өрийг төлөөгүй байгаатай холбоотой байна. Мөн НДШ болон бараа үйлчилгээний зардлуудын өр нэмэгджээ.

-Урт хугацаат өглөгийн талаар

Тус компани нь Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлээр хэрэгжсэн төслийн зээлийн 991,1 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөртэй байна. Урт хугацаат өр төлбөрөөс төлбөр хийгдээгүй байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл баталгаажуулалт, тооцоо нийлэлт

Өр төлбөрийн дансны үлдэгдлийг татвар, НДШ-ийн өрийг татвар, НДШ-ийн тайлангаар, байгууллагуудыг байгууллага тус бүртэй тооцоо нийлж баталгаажуулсан байна.

6. Орлого, татаас санхүүжилтийн талаар

6.1 Үндсэн үйл ажиллагааны орлогын талаар

Тус компани нь тайланд онд нийтдээ 871.8 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, орлогын төлөвлөгөөг 3.7 сая төгрөгөөр буюу 4.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 672.1 сая төгрөгийн орлого оруулсны 251.2 сая төгрөг буюу 37,3 хувь нь цэвэр усны, 281,4 сая төгрөг буюу 44.1 хувь нь бохир усны, 137,8 сая төгрөг буюу 18.6 хувь нь халуун усны орлого байна.

6.2 Туслах үйл ажиллагааны орлогын талаар

Туслах үйл ажиллагаанаас 199.8 сая төгрөгийн орлого оруулсны 6.4 сая төгрөг буюу 3.2 хувь нь цэвэр усны жижиг үйлдвэрийн орлого, 9.5 сая төгрөг буюу 4.7 хувь нь блокны үйлдвэрийн орлого, 178.9 сая төгрөг буюу 89.5 хувь нь барилга угсралтын орлого байна.

6.3 Бусад

Бусад орлогоос 4.9 сая төгрөг орсон нь түрээс, ус зөөх, засвар үйлчилгээний орлого байна.

Орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/					
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	936,8	1114,7	119	177,9
1.1	Урсгал зардал	936,8	1114,7	119	177,9
1.2	Хөрөнгийн зардал				
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр				
2.1	Үйл ажиллагааны орлогоос	868,1	871,8	100,4	3,7

7. Зардлын талаар

7.1 Үндсэн үйл ажиллагааны зардлын талаар

Үндсэн үйл ажиллагаанд 811,4 сая төгрөгийн зардлыг төлөвлөгөөт орлогоос 96,5 сая төгрөг илүү зардлаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагаанд 817,4 сая төгрөг зарцуулж, 145,4 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна. Үндсэн үйл ажиллагааны зардлын 386,9 сая төгрөгийг буюу 47,3 хувийг цэвэр усны, 317,4 сая төгрөгийг буюу 38,8 хувийг бохир усны, 113,0 сая төгрөгийг буюу 13,8 хувийг халуун усны зардал эзэлж байна.

7.2 Туслах үйл ажиллагааны зардлын талаар

Туслах үйл ажиллагаанд 125,3 сая төгрөгийн зардал төлөвлөснөөс 297,3 сая төгрөгийн зардал гаргаж, төлөвлөснөөс 172,0 сая төгрөгийн зардлыг төлөвлөснөөс илүү зарцуулжээ. Туслах үйл ажиллагааны зардлын 6,3 сая төгрөгийг буюу 2,1 хувийг жижиг үйлдвэрийн зардал, 8,3 сая төгрөгийг буюу 2,8 хувийг блокны үйлдвэрийн, 274,9 сая төгрөгийг буюу 92,4 хувийг барилга угсаралтын зардал эзэлж байна.

7.3 Бусад

Бусад зардал гараагүй байна.

8. Хуримтлагдсан үр дүнгийн талаар

Тайлант онд 242,8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Хуримтлагдсан алдагдал 223,4 сая төгрөгт хүрсэн байна. Үндсэн үйл ажиллагаанаас захиргааны зардлыг оролцуулан 145,4 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 97,5 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

9. Эзэмшигчийн өмчийн талаар

Эзэмшигчийн өмч 2951,1 сая төгрөг бөгөөд үүний 2336,8 сая төгрөг буюу 79,2 хувийг төгрөг нь орон нутгийн өмч, 837,7 сая төгрөг буюу 28,3 хувийг нь хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл эзэлж байна. Хуримтлагдсан үр дүн -223,4 сая төгрөг болж, нийт эзэмшигчийн өмчийг 7,5 хувиар бууруулсан байна.

10. Дахин үнэлгээний нөөцийн талаар

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс 837,7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

11. Хөрөнгө оруулалтын талаар

Өөрийн хөрөнгөөр конторын барилга барихад тайлант онд 30,3 сая төгрөг нэмж зарцуулж, конторын барилгад нийтдээ 194,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

12. Бусад асуудал Байхгүй

1.12 Шилэн дансны мэдээлэл

"Суат" ХХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 6 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 6 горим сорил хэрэгжүүлэв.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

1.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид "Суат" ХХК-ны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Суат" ХХК-ны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажилгүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударгайлэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Суат" ХХК-ны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээнэвч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

2.1 АВЛАГА, ӨР ТӨЛБӨР ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛ №2

БӨ АГ-ын илрүүлэлт

"Суат" ХХК-ны санхүүгийн тайланд 2015 оноос Нэгдсэн эмнэлгээс 27,6 сая төгрөгийн авлагыг бүртгэж тусгасан боловч харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, тухайн авлагыг харилцагч байгууллага нь хүлээн зөвшөөрөөгүй, авлагын насжилт нэмэгдсэн байна.

БӨ АГ-ын Зөвлөмж

Нэгдсэн эмнэлгэтэй холбоотой 27,6 сая төгрөгийн авлагыг харилцагч байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулах, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Хариуцах ажилтан

Захирал Ж.Адалбек,
Нягтлан бодогч А.Нуртуган

Эрсдэл

Дээрхи асуудал нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байдал зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрсөн.

3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**3.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Дансны код	Балансын үзүүлэлт	/мян.төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	328,916.6	248,149.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,584.1	10,352.8
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	4,031.9	8,137.9
31110	Төгрөг	4,031.9	8,137.9
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,552.2	2,214.9
3121	Төгрөг	2,552.2	2,214.9
31213	Арилжааны банк дахь харилцах	2,552.2	2,214.9
33	АВЛАГА	51,784.8	118,707.9
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	0.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	18,642.6	30,934.0
33401	Дансны авлага /ТӨҮГ/	33,142.2	87,774.0
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	0.0	0.0
335	Бусад авлага	0.0	0.0
3351	Байгууллагаас авах авлага	0.0	0.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага	0.0	0.0
336	Зээлийн авлага	0.0	0.0
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	0.0	0.0
3362	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	0.0	0.0
34	УРЬДЧИЛГАА	171,144.9	35,102.9
34500	Хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн газар	171,144.9	35,102.9
34600	Урьдчилж гарсан зардал	0.0	0.0
3471	Урьдчилгаа тооцоо	0.0	0.0
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.0	0.0
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	0.0	0.0
34713	Цалингийн урьдчилгаа	0.0	0.0
34714	Томилолтын урьдчилгаа	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	99,402.8	83,985.8
351	Түүхий эд материал	83,850.0	75,309.2
35110	Тусгай зориулалттай материал	83,850.0	75,309.2
354	Хангамжийн материал	15,552.8	8,676.5
35410	Бичиг хэргийн материал	0.0	0.0
35420	Аж ахуйн материал	132.6	2,892.6
35430	Сэлбэг хэрэгсэл	3,052.0	2,796.5
35440	Түлш, шатах тослох материал	830.2	735.6
35450	Барилгын засварын материал	1,596.9	1,596.9
35460	Хүнсний материал	0.0	0.0

35470	Бусад хангамжийн материал	9,941.1	654.9
35500	Биологийн хөрөнгө	0.0	0.0
35600	Мал амьтад	0.0	0.0
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,922,438.3	3,849,429.8
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,922,438.3	3,849,429.8
391	Газар	0.0	0.0
392	Биет хөрөнгө	3,921,860.3	3,848,851.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,325,600.2	4,325,600.2
39202	Хуримтлагдсан элэгдэл	-979,274.3	-1,052,228.6
39203	Авто-тээврийн хэрэгсэл	382,920.9	382,920.9
39204	Хуримтлагдсан элэгдэл	-177,398.7	-202,749.4
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	738,545.3	763,085.8
39206	Хуримтлагдсан элэгдэл	-542,282.3	-571,665.8
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,817.8	64,617.8
39208	Хуримтлагдсан элэгдэл	-53,180.2	-55,185.2
39216	Дуусаагүй барилга, байгууламж	164,111.6	194,456.1
39217	Ном	0.0	0.0
393	Биет бус хөрөнгө	578.0	578.0
39301	Програм хангамж	578.0	578.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.0	0.0
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,251,354.9	4,097,579.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,057,346.0	1,146,424.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	66,287.4	155,365.3
413	Өглөг	66,287.4	155,365.3
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,746.7	0.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	5,675.1	44,227.4
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	0.0	0.0
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	0.0	0.0
41350	Зээлийн хүүгийн өглөг	0.0	0.0
4136	Бусад өглөг	49,865.5	111,137.9
41361	Байгууллагад төлөх өглөг	0.0	0.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.0	0.0
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	41,871.0	95,533.6
41364	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	7,994.6	15,604.3
41365	Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/	0.0	0.0
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	0.0	0.0
414	Урьдчилж орсон орлого	0.0	0.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	991,058.7	991,058.7
422	Урт хугацаат зээл	991,058.7	991,058.7
4221	Төгрөг	991,058.7	991,058.7
42217	Санхүүгийн бусад байгууллага	991,058.7	991,058.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,194,008.9	2,951,155.2

51	Засгийн газрын хувь оролцоо	3,194,008.9	2,951,155.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,336,846.5	2,336,846.5
51101	Өмч: - төрийн	2,336,846.5	2,336,846.5
51102	- хувийн	0.0	0.0
51103	- хувьцаат	0.0	0.0
51104	Халаасны хувьцаа	0.0	0.0
51105	Нэмж төлөгдсөн капитал	0.0	0.0
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	0.0	0.0
512	Хуримтлагдсан үр дүн	19,461.1	-223,392.6
51210	Өмнөх үеийн үр дүн	0.0	19,461.1
51220	Тайлант үеийн үр дүн	19,461.1	-242,853.7
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.0	0.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	837,701.2	837,701.2
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	0.0
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.0	0.0
51600	Нөөцийн сан	0.0	0.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,251,354.9</u>	<u>4,097,579.1</u>

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мян. төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	820,303.9	871,853.4
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	699,778.5	991,243.6
	НИЙТ АШИГ	120,525.5	-119,390.2
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	112,068.7	123,463.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	112,068.7	123,463.5
210	ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ	112,068.7	123,463.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	83,021.8	85,918.5
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	83,021.8	85,918.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,979.8	9,451.0
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	8,979.8	9,451.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	611.1	252.5
210301	Гэрэл, цахилгаан	611.1	252.5
2104	Хангамж, бараа материалын зардал	6,119.5	11,110.3
210401	Бичиг хэрэг	793.1	732.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	519.0	961.1
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	4,807.5	9,416.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	1,918.6
210604	Урсгал засвар	0.0	1,918.6
2107	Томилолт, зочны зардал	1,046.8	1,108.2
210702	Дотоод албан томилолт	1,046.8	1,108.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,350.7	2,353.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,405.0	2,330.9
210813	Бусад зардал /ТӨҮГ/		22.5
210814	Орлогын татварын зардал /ТӨҮГ/	945.6	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,939.0	11,351.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	70.0	1,155.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	9,869.0	10,196.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,510.7	-242,853.7
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз		
145003	Хөрөнгө оруулалтын олз		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
225003	Хөрөнгө оруулалтын гарз		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,510.7	-242,853.7
	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	851.1	
	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	7,659.6	-242,853.7

4.3 Аудит хийсэн ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ мян.төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,336,846.5	837,701.2	19,461.1	0.0	3,194,008.9
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,336,846.5	837,701.2	19,461.1	0.0	3,194,008.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0	0.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,336,846.5	837,701.2	19,461.1	0.0	3,194,008.9
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.0	0.0	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.0	0.0	0.0	0.0	0.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-242,853.7	0.0	-242,853.7
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,336,846.5	837,701.2	-223,392.6	0.0	2,951,155.2

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мян.төг /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	897,106.5	982,590.7
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	897,106.5	982,590.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,041,609.1	978,822.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	279,724.9	292,964.4
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	279,724.9	292,964.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,000.0	71,400.0
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	62,000.0	71,400.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,744.8	118,707.2
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	99,744.8	118,707.2
2104	Хангамж, бараа материалын зардал	141,946.2	82,973.6
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	89,665.5	8,721.5
210408	Бараа материал акталсны зардал		
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	52,280.7	74,252.1
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	458,193.3	412,777.0
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	93,462.1	60,043.9
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	0.0	1,760.0
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	364,731.2	350,973.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-144,502.6	3,768.6
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.0	0.0
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
140002	Улсын төсвөөс олгосон зээл		
140003	Бусдад олгосон зээл болон урьдчилгааны эргэн төлөлт		
140004	Хөрөнгө оруулалтын олз		
140005	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
140006	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
140007	Хүлээн авсан хүүний орлого		
140008	Хүлээн авсан ногдол ашиг		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	0.0	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
225101	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		

225103	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		
225104	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		
225105	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа /ТӨҮГ/		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
145006	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих		
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
145008	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
145009	Төрөл бүрийн хандив		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
250004	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
250005	Төлсөн ногдол ашиг		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-144,502.6	3,768.6
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	151,086.8	6,584.1
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,584.1	10,352.8

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

ӨЛГИЙ-АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

М.АЛТАНГҮЛ

2017.03.15